



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/147/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал  
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: [ariunaach@audit.gov.mn](mailto:ariunaach@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: [enkhtsetsege@audit.gov.mn](mailto:enkhtsetsege@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: [uwaauul.audit@gmail.com](mailto:uwaauul.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1. Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2020.02.28 № 1-6/145  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН  
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Б.АДИЛБИШ ТАНАА**

**Аудитын гэрчилгээ**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Адилбиш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 28-наас 2020 оны 2 дугаар сарын 18-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар “Уваа-уул аудит” ХХК –ийн захирал Ч.Мөнхтуяа, чанар хяналтын менежер А.Оюун, аудитор Ц.Мөнхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь улс орны бүтээн байгуулалтад манлайлан оролцогч чадварлаг ажилтныг нийгмийн бодит түншлэлд тулгуурлан бэлтгэж, мэргэжлээрээ баян чинээлэг амьдрах боломжийг олгоход оршино.

Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

“Төрийн албаны тухай” шинэчилсэн хуулийг дагаж гарсан эрх зүйн актууд 2019 оноос эхлэн үйлчилж байна. Тухайлбал:

- Журам батлах тухай (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох) Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох) Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Нөхөх төлбөр олгох) Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол
- Журам батлах тухай (Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох) Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол
- Журам батлах тухай (төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох ) Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол гэх мэт.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous-3” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд эрсдэлтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувийг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” гэж үзсэнтэй холбоотой юм.

. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 14,299.4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн үе шат болон нийт зардлын дүнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 159,290.5 мянган төгрөгөөр буюу 4,0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,475.3	3695.3	1,220.0
Авлага	419.9	35,089.1	34,669.2
Урьдчилгаа	1320.0		-1,320.0
Бараа материал	175,393.9	193,844.2	18,450.3
Үндсэн хөрөнгө	3,756,682.9	3,544,372.9	-212,310.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,936,292.0</b>	<b>3,777,001.5</b>	<b>-159,290.5</b>
Өр төлбөр	1,220.5	172.3	-1,048.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,935,071.5	3,776,829.2	-355,518.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,936,292.0</b>	<b>3,777,001.5</b>	<b>-159,290.5</b>

Авлага дансны үлдэгдэл өссөн нь жилийн эцэст 34,860.8 мянган төгрөгийг нэмэлт төсвийн данснаас төсөвт төвлөрүүлснийг авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 1994 – 2019 онуудад үүссэн авлага байгаагаас он удаан жил болсон 85.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь аж ахуйн материал дансны үлдэгдэл 13,676.7 мянган төгрөг, барилгын засварын материал дансны үлдэгдэл 2,692.8 мянган төгрөг, хүнсний материал 3,151.4 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс голлон шалтгаалжээ. Аж ахуйн материал дансны өсөлт нь хандив болон дэмжлэгээр бий болсон сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгслээр, барилгын засварын материал дансны үлдэгдэл нь сургалт, хичээл үйлдвэрлэлийн дадлагад хэрэглэгдэх материалын дүнгээр, хүнсний материалын дансны үлдэгдэл нь дотуур байрны хүүхдийн хоолны материалаар тус тус өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 212,310.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн элэгдлийн зардал, дахин үнэлэгдсэн үл хөдлөх хөрөнгийн залруулга, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Биет бус хөрөнгийн бууралт 160,4 мянган төгрөг нь программ хангамжийн элэгдлийн дүн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,048.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,776,829.2 мянган төгрөг болж 158,242.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 84,350.8 мянган төгрөгийн алдагдалтай гарсан, өмнөх үеийн үр дүнд 72,897.7 мянган төгрөгийн залруулга хийсэн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 993,9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 72,897.7 мянган төгрөгийн бичилт нь 2018 онд дахин үнэлгээ хийгдсэн үл хөдлөх хөрөнгийн үнэд залруулга хийсэнтэй холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь тайлант онд 8,500.0 мянган төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөтэй боловч гүйцэтгэлээр 3,792.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 44,6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,500.0	3,792.0	4,708.0	44,6
Нийт дүн	8,500.0	3,792.0	4,708.0	44,6

Төсөвт байгууллагын өөрийн орлого 4,708.0 мянган төгрөгөөр тасарсан нь үйлдвэрлэлийн дадлагын орлогыг бүрдүүлж чадаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 1,222,067.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь бүхэлдээ урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,213,567.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,500.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг авч үзвэл улсын төсвөөс батлагдсаны дагуу 1,213,567.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон бол өөрийн орлогын төлөвлөгөө 4,708.0 мянган төгрөгөөр тасалдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл батлагдсан орон тооноос 5 орон тоо дутуу ажилласнаас шалтгаалан цалин, шимтгэлийн зардал 51,839.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, элсэгчдийн тоо элсэлтийн квотод хүрээгүй, дотуур байранд амьдрах хүүхдийн тоо тогтворгүй байгаагаас шалтгаалан нормативт зардал 3,930.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, тэтгэвэрт гарах байсан багш тэтгэвэртээ гараагүйгээс шалтгаалан тэтгэмжийн зардал гараагүй зэрэг нь төсвийн гүйцэтгэл төлөвлөснөөс 65,812.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулах шалтгаан болсон байна.

Эдгээр шалтгааны улмаас төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,156,255.4 мянган төгрөг буюу 94,6 хувьтай гарсан байна.

**Нэмэлт төсөв:**, Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газраас сургалтын орчныг сайжруулах зорилгоор өгсөн 26,407.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 56,849.0 мянга, нийт 83,256.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого нь түр сургалтын орлого, сургах зүйн чадамж эзэмшүүлэх төлбөр, говийн бүсийн физик, математикийн олимпиад, төмөр замын суралцагчдын сургалтын орлого зэрэг төсвийн жилийн дундуур бий болсон орлогууд орсон байна.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 27,541.5 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 20,854.2 мянга, нийт 48,395.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 34,860.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 24 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 20 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 81,960.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 73,880.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,708.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3,372.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 8,080.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4,708.0 төгрөгийн албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2019 онд батлагдсан төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 4,708.0 мянган төгрөгөөр тасалдуулсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 16,998.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 16,998.4 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, 100 %-ийн биелэлттэй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 8,080.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 14,299.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт Оюутны дотуур байрны хоолны зардлыг 3372,3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан. Энэ нь “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолыг заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.1.2 Эрсдэл: Дотуур байрны оюутны хоолонд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, илчлэг, шимт бодисын хэмжээ нормативдаа хүрэхгүй байх
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, батлагдсан норм, нормативыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөв.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийг зөрчиж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.
- 3.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгийн үнэ цэнэ буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх үр дагавартай.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>179,609,092.08</u></b>	<b><u>232,628,553.68</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,475,250.00	3,695,250.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,475,250.00	3,695,250.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,475,250.00	3,695,250.00
31211	Төрийн сангийн харилцах	2,475,250.00	3,695,250.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	419,946.00	35,089,104.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	34,860,790.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	419,946.00	228,314.00
3351	Байгууллагаас авах авлага	183,211.00	98,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	236,735.00	130,314.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	1,320,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,320,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	175,393,896.08	193,844,199.68
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	175,393,896.08	193,844,199.68
35410	Бичиг хэргийн материал	1,660,820.00	1,444,200.00
35420	Аж ахуйн материал	163,668,678.34	177,345,378.91
35450	Барилгын засварын материал	5,372,070.00	8,064,890.00
35460	Хүнсний материал	2,767,855.74	5,919,282.77
35470	Бусад хангамжийн материал	1,924,472.00	1,070,448.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,756,682,894.12</u></b>	<b><u>3,544,372,883.44</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,756,682,894.12	3,544,372,883.44
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,321,162,477.33	3,109,012,883.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,115,173,204.12	3,041,292,849.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,962,146.90	-159,370,526.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,200,000.00	60,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,662,301.42	-59,852,777.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,188,928,259.34	1,226,837,580.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,056,840,334.13	-1,116,772,524.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	182,631,745.59	198,132,792.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-129,508,107.70	-140,139,084.21
39217	Ном	79,202,158.43	58,684,573.19
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	435,520,416.79	435,360,000.00
39301	Програм хангамж	16,830,000.00	16,830,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-16,669,583.21	-16,830,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	435,360,000.00	435,360,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,936,291,986.20</u></b>	<b><u>3,777,001,437.12</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,220,454.00</u></b>	<b><u>172,263.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,220,454.00	172,263.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,220,454.00	172,263.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	231,095.00	83,263.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	989,359.00	89,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	43,000.00	89,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	946,359.00	00.00

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,935,071,532.20</b>	<b>3,776,829,174.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,935,071,532.20	3,776,829,174.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,930,456,307.08	1,930,456,307.08
51101	Өмч: - төрийн	1,930,456,307.08	1,930,456,307.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	998,238,566.14	840,990,080.87
51210	Өмнөх үеийн үр дүн	998,238,566.14	925,340,839.66
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-84,350,758.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,006,376,658.98	1,005,382,786.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,936,291,986.20</b>	<b>3,777,001,437.12</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,044,104,286.00</b>	<b>1,384,330,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,360,000.00</b>	<b>87,506,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,360,000.00	87,506,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,360,000.00	87,506,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,360,000.00	3,693,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	80,813,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,038,744,286.00</b>	<b>1,296,824,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,031,738,400.00	1,213,567,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,031,738,400.00	1,213,567,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,600,000.00	83,256,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,407,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,600,000.00	56,849,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	405,886.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	405,886.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,279,678,079.83</b>	<b>1,436,698,703.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,279,678,079.83</b>	<b>1,436,698,703.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,146,518,706.88	1,371,258,615.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	539,841,340.00	716,830,547.00
210101	Үндсэн цалин	373,788,721.00	490,607,957.00
210102	Нэмэгдэл	123,775,019.00	138,564,739.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,277,600.00	46,969,000.00
210104	Урамшуулал	00.00	40,688,851.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,012,770.00	89,148,987.00
210201	Тэтгэврийн даатгал	65,012,770.00	60,621,311.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	7,131,919.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,705,535.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,426,384.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	14,263,838.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	164,047,730.00	193,360,300.00
210301	Гэрэл, цахилгаан	12,352,060.00	13,750,526.00
210302	Түлш, халаалт	134,369,158.00	161,119,131.00
210303	Цэвэр, бохир ус	17,326,512.00	18,490,643.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,012,888.61	23,019,062.58
210401	Бичиг хэрэг	3,384,997.00	6,607,378.00
210402	Тээвэр, шатахуун	2,996,604.00	5,387,096.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,850,452.20	3,954,109.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,000.00	700,000.00
210408	Бараа материал акталсны зардал	11,110,835.41	6,370,478.43
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	35,816,308.64	43,869,681.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	256,150.00	276,675.00
210502	Хоол, хүнс	31,162,810.64	40,228,368.42
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,397,348.00	3,364,638.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	40,217,740.00	19,327,390.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	580,000.00
210604	Урсгал засвар	40,217,740.00	18,747,390.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,988,500.00	4,413,500.00
210702	Дотоод албан томилолт	3,988,500.00	4,413,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,383,551.00	5,062,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,502,909.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,694,683.00	2,694,683.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,868.00	160,868.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	99,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	271,197,878.63	276,226,287.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,332,746.00	81,911,436.55
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,865,132.63	194,314,851.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	133,159,372.95	65,440,087.85
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	63,572,654.00	4,336,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,780,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,860,768.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,206,386.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	505,500.00	2,556,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	69,586,718.95	61,104,087.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,586,718.95	61,104,087.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-235,573,793.83</b>	<b>-52,367,903.59</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	31,982,855.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	31,982,855.20
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)</b>	00.00	-31,982,855.20

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>-235,573,793.83</b>	<b>-84,350,758.79</b>
---	-------------------------	------------------------	-----------------------

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,049,110,685.00</b>	<b>1,303,616,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,444,078.00</b>	<b>6,792,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,444,078.00	6,792,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	5,444,078.00	6,792,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,360,000.00	3,792,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	84,078.00	3,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,031,738,400.00</b>	<b>1,296,824,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,031,738,400.00	1,213,567,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,031,738,400.00	1,213,567,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,600,000.00	83,256,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,407,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,600,000.00	56,849,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,328,207.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,328,207.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,049,824,685.00</b>	<b>1,281,296,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,049,824,685.00</b>	<b>1,281,296,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>910,833,105.05</b>	<b>1,180,095,122.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	539,719,381.00	717,038,609.00
210101	Үндсэн цалин	373,666,762.00	490,816,019.00
210102	Нэмэгдэл	123,775,019.00	138,564,739.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,277,600.00	46,969,000.00
210104	Урамшуулал	00.00	40,688,851.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,475,611.00	89,131,759.00
210201	Тэтгэврийн даатгал	64,475,611.00	60,609,596.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	7,130,541.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	5,704,433.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,426,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	14,261,081.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	140,537,567.00	193,360,300.00
210301	Гэрэл, цахилгаан	12,352,060.00	13,750,526.00
210302	Түлш, халаалт	112,091,331.00	161,119,131.00
210303	Цэвэр, бохир ус	16,094,176.00	18,490,643.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,347,691.20	16,268,340.15
210401	Бичиг хэрэг	3,154,445.00	5,673,835.00
210402	Тээвэр, шатахуун	4,203,694.00	4,395,396.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,073,552.20	3,954,109.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,000.00	700,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,246,000.00	1,544,999.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>36,294,525.85</b>	<b>47,311,614.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	304,650.00	276,675.00
210502	Хоол, хүнс	32,644,255.85	43,658,805.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,345,620.00	3,376,134.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,905,820.00</b>	<b>28,061,430.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,717,900.00	1,134,950.00
210602	Тавилга	00.00	644,000.00
210604	Урсгал засвар	22,187,920.00	26,282,480.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,988,500.00</b>	<b>4,413,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,988,500.00	4,413,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,383,551.00</b>	<b>4,443,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	883,409.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,694,683.00	2,694,683.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,868.00	160,868.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	99,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>83,180,458.00</b>	<b>80,066,210.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,180,458.00	80,066,210.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>138,991,579.95</b>	<b>101,200,877.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>69,404,861.00</b>	<b>5,236,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,328,207.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,780,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,860,768.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,206,386.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,009,500.00	3,456,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>69,586,718.95</b>	<b>95,964,877.85</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,586,718.95	95,964,877.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-714,000.00</u></b>	<b><u>22,320,000.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>295,500.00</u></b>	<b><u>21,100,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>295,500.00</u></b>	<b><u>21,100,000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>295,500.00</b>	<b>21,100,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	295,500.00	21,100,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>-295,500.00</u></b>	<b><u>-21,100,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-1,009,500.00</b>	<b>1,220,000.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,484,750.00	2,475,250.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,475,250.00	3,695,250.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,495,096,307.08	876,540,400.32	860,248,502.87	3,231,885,210.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,495,096,307.08</b>	<b>876,540,400.32</b>	<b>860,248,502.87</b>	3,231,885,210.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,849,041.75	-44,849,041.75
<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,930,456,307.08</b>	<b>1,006,376,658.98</b>	<b>998,238,566.14</b>	3,935,071,532.20
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,930,456,307.08</b>	<b>1,006,376,658.98</b>	<b>998,238,566.14</b>	3,935,071,532.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-72,897,726.48	-72,897,726.48
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,930,456,307.08</b>	<b>1,006,376,658.98</b>	<b>925,340,839.66</b>	3,862,173,805.72
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-993,872.81	00.00	-993,872.81
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-84,350,758.79	-84,350,758.79
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,930,456,307.08</b>	<b>1,005,382,786.17</b>	<b>840,990,080.87</b>	3,776,829,174.12

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,222,067,500.00	1,156,255,412.15
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,222,067,500.00	1,156,255,412.15
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,208,595,600.00	1,152,799,412.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	762,675,100.00	717,038,609.00
210101	Үндсэн цалин	543,957,600.00	490,816,019.00
210102	Нэмэгдэл	114,960,800.00	138,564,739.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,362,000.00	46,969,000.00
210104	Урамшуулал	60,394,700.00	40,688,851.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	95,334,500.00	89,131,759.00
210201	Тэтгэврийн даатгал	64,827,400.00	60,609,596.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,626,800.00	7,130,641.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,101,400.00	5,704,433.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,525,400.00	1,426,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,253,500.00	14,261,081.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	193,360,300.00	193,360,300.00
210301	Гэрэл, цахилгаан	10,972,400.00	13,750,526.00
210302	Түлш, халаалт	161,119,700.00	161,119,131.00
210303	Цэвэр, бохир ус	21,268,200.00	18,490,643.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,348,600.00	16,348,340.15
210401	Бичиг хэрэг	3,366,000.00	5,753,835.00
210402	Тээвэр, шатахуун	4,207,500.00	4,395,396.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,544,100.00	3,954,109.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,381,000.00	1,544,999.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	51,241,900.00	47,311,614.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	386,800.00	276,675.00
210502	Хоол, хүнс	47,588,100.00	43,658,805.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,267,000.00	3,376,134.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,541,300.00	21,539,930.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,534,500.00	1,134,950.00
210604	Урсгал засвар	20,006,800.00	20,404,980.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,417,900.00	4,413,500.00
210702	Дотоод албан томилолт	4,417,900.00	4,413,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,464,000.00	4,443,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	895,200.00	883,409.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,700,000.00	2,694,683.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,000.00	160,868.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	99,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	59212000.00	59212000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,212,000.00	59,212,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13471900.00	3456000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,471,900.00	3,456,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,971,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,456,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,222,067,500.00	1,156,255,412.15
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,213,567,500.00	1,152,463,412.15
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,213,567,500.00	1,152,463,412.15
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	8,500,000.00	3,792,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	3,792,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	2,475,250.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	3,695,250.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>70.00</b>	<b>65.00</b>
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	42.00	38.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28.00	27.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>48,395,710.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>48,395,710.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	48,395,710.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,541,500.00
210602	Тавилга	21,664,000.00
210604	Урсгал засвар	5,877,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,854,210.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,854,210.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	83,256,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	83,256,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,407,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,849,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020-02-25			ДГА-2020/147/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн МСҮТ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасалдсан	4,708.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Адилбиш У.Дэлгэрбуян
2	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд ашиглагдаж байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Адилбиш У.Дэлгэрбуян
3	Дотуур байрны хоолны зардал нормативаас дутуу зарцуулагдсан	3,372.3	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Адилбиш У.Дэлгэрбуян